

  
**БАЯНХОНГОР АЙМАГ**  
**БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**  
**ЗАХИРАМЖ**

10/24 оны 08 сарын 15 өдөр

Дугаар A/24

Баянсайр

Г Засаг даргын нөөц хөрөнгөөс  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны A/27 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2024 оны 1 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Тус сумын өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч хөдөөгийн багуудад өвс тэжээл газар дээр нь хүрч хүргэх, төрийн үйлчилгээг малчны хотонд хүргэж ажиллах, цаг үеийн нөхцөл байдлын судалгаа, тандалт авах, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан бусад тохиолдлоор сумын Онцгой комисст ирүүлсэн дуудлагын мөрөөр хүн эрэн хайх зэрэгт зарцуулсан шатахууны зардал 4,769,000 (Дөрвөн сая долоон жаран есөн мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.

2.Тус хөрөнгийн зарцуулалтыг журмын дагуу зарцуулж тайлагнахыг төсвийн шууд захирагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Наранбаатар), Санхүүгийн албаны дарга (Б.Гэрэлмөнх), Тамгын газрын нягтлан бодогч (Д.Анхтуяа) нарт үүрэг болгосугай.



642301239